



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 500

Улаанбаатар хот

“Монголын хөрөнгийн бирж” ХК-д нэр бүхий
хувьцаат компаниудын үнэт цаасыг бүртгэлээсээ хасахыг зөвшөөрөх тухай

Хавсралтад нэр дурдсан компаниуд нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Компанийн тухай хуульд заасан хугацаанд зарлан хуралдуулаагүй, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3, 10.1.4, 10.1.5 дахь заалтуудыг хэрэгжүүлээгүй, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан журмын дагуу хувьцаа эзэмшигчдэд хүргэх ёстой мэдээллийг хуульд заасан хугацаанд хүргээгүй, Хорооноос өгсөн хугацаатай үүрэг, даалгаварыг биелүүлээгүй зэрэг зөрчлүүдийг удаа дараа гаргасан, мөн түүнчлэн “Монголын хөрөнгийн бирж” ХК-иас 2013 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 1/531 тоот албан бичгээр нэр бүхий компаниуд нь Хөрөнгийн биржийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын шалгуур үзүүлэлт, бусад нөхцөл шаардлагыг хангаж ажиллахгүй байгаа тул өөрийн бүртгэлээс хасах шаардлагатай байгаа тухай хүсэлт ирүүлснийг тус тус ТЭМДЭГЛЭН:

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.1 дэх заалт болон Улсын Их Хурлын 2013 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 41 дүгээр тогтоолын 1 дэх заалтын 3 дахь хэсэг, Хорооны даргын 2013 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 43 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Энэхүү тогтоолын хавсралтад дурьдсан нэр бүхий 12 /арван хоёр/ хувьцаат компанийн нийтэд санал болгон гаргасан үнэт цаасыг өөрийн бүртгэлээсээ хасахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/-д зөвшөөрсүгэй.

2. Нэр бүхий 12 /арван хоёр/ хувьцаат компанийн үнэт цаасыг бүртгэлээс хассан шийдвэрээ Хороонд ирүүлж, энэ талаарх мэдээллийг олон нийтэд хүргэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.


ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000015

Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 12 ны өдрийн 500 дугаар тогтоолын хавсралт



“Монголын хөрөнгийн бирж” ХК-д үнэт цаасны бүртгэлээсээ хасахыг зөвшөөрсөн нэр бүхий 12 /арван хоёр/ хувьцаат компанийн нэрсийн жагсаалт

№	Компанийн оноосон нэр	Үнэт цаасны код	Гаргасан хувьцааны тоо
1	"Торгон үр" ХК	415	171,657
2	"Дорнод ноос" ХК	381	462,929
3	"Алтай Ханын Материал"ХК	240	63,396
4	"Дар зам" ХК	470	616,848
5	"Мандал Оргил" ХК	261	68,968
6	"Улбаа" ХК	210	112,646
7	"Сүмбэр -Өлзий" ХК	266	114,834
8	"Тээвэр Төв"ХК	439	207,791
9	"Говь сүмбэр"ХК	344	97,149
10	"Улаан хотгор" ХК	422	97,322
11	"Жинчин" ХК	155	80,601
12	"Арилжаа " ХК	122	52,777

-оОо-

Handwritten signatures and faint red stamps at the bottom of the page.